



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/187

Улаанбаатар хот

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62.1.1, 62.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/703 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/703 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан "Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Их тойруугийн гудамж-Урд хэсэг", "Нийтийн эзэмшлийн явган хүний зам, талбайн тохижилтын ажил, Бага тойруугийн гудамж-Урд хэсэг" төсөл арга хэмжээнүүдийг чиг үүргийн дагуу гүйцэтгэж, үр дүнг танилцуулж ажиллахыг Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨААТҮГ (Э.Онон)-т үүрэг болгосугай.

2.Дээрх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, тогтоомж, норм, стандартад нийцүүлэн гүйцэтгэхэд хяналт тавьж, ажлын үр дүнг танилцуулан ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс (М.Цогтбилэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Бямбажав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ

1525010595